# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тариалан сумын Соёлын төвийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2025/021/НА-СТА-ТШЗ**


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран
Утас: 99389927 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Гурван Хөх Морьт Аудит ХХК
Гүйцэтгэх захирал: Н.Отгончимэг
Утас: 99051815 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com
Аудитор: Д.Соёлсайхан
Утас: 91929196 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com



Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2025 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 1/266

танай ____________-ны № ____________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН
СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ДАРГА
Б.БААСАНСҮРЭН ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тариалан сумын Соёлын төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 8,680.0 мянган төгрөгийн тавилга тоног төхөөрөмж, ном шилжүүлэн авсан, 1,900.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, бусад эх үүсвэрээс 9,210.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг тус тус хүлээн авч байгууллагын тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн байна.

### Аудитын гол асуудал байхгүй

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй

Тайлант онд 10,477.5 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийн үнийг шинэчлэн тогтоогоогүй, албан хаагчийн ажиллаж байсан хугацааны амралтын тооцоо хийгээгүй, шилэн дансанд байршуулах 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, тушаал шийдвэрүүдийг бүрэн мэдээлээгүй зэрэг зөрчил илэрсэн.

### Бусад асуудлын хэсэг

Тус соёлын төвийн дарга нь Хөвсгөл аймгийн Тариалан сумын засаг даргатай 2024 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 89.0 хувь, төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх хөтөлбөр арга хэмжээний биелэлт 92.3 хувьтай байна.

6725021872

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **60,304,532.97** | **33,655,880.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **25,138,709.77** | **-** |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 25,138,709.77 | - |
| 3121 | Төгрөг | 25,138,709.77 | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 25,138,709.77 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **33,165,823.20** | **33,655,880.00** |
| 354 | Хангамжийн материал | 33,165,823.20 | 33,655,880.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 17,092,803.00 | 10,857,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 18,073,020.20 | 22,798,880.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,770,342,849.35** | **3,687,135,608.20** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **3,770,342,849.35** | **3,687,135,608.20** |
| 392 | Биет хөрөнгө | 3,750,108,849.39 | 3,667,227,608.28 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 4,221,206,373.47 | 4,221,206,373.47 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (541,810,662.08) | (635,458,075.16) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 70,675,348.90 | 86,066,238.90 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (45,096,618.96) | (53,755,464.19) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 8,008,792.20 | 11,408,792.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (4,582,408.14) | (4,948,280.94) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 13,015,500.00 | 13,015,500.00 |
| 39217 | Ном | 28,692,524.00 | 29,692,524.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 20,233,999.96 | 19,907,999.92 |
| 39301 | Программ хангамж | 1,630,000.00 | 1,630,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (392,000.04) | (718,000.08) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,996,000.00 | 18,996,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,830,647,382.32** | **3,720,791,488.20** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **10,477,454.50** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **10,477,454.50** |
| 413 | Өглөг | - | 10,477,454.50 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 10,477,454.50 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,830,647,382.32** | **3,711,150,083.66** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,830,647,382.32 | 3,711,150,083.66 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 173,579,922.10 | 173,579,922.10 |
| 51101 | Өмч: - төрийн | 173,579,922.10 | 173,579,922.10 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 3,037,630,987.17 | 2,917,297,638.55 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,045,953,165.71 | 3,037,630,987.17 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (8,322,178.54) | (120,333,348.62) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 619,436,473.05 | 619,436,473.05 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,830,647,382.32** | **3,720,791,488.20** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **426,856,649.58** | **470,142,537.20** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **29,819,300.00** | **21,350,890.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 29,819,300.00 | 21,350,890.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 29,819,300.00 | 21,350,890.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 913,800.00 | 10,240,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,370,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 27,535,500.00 | 11,110,890.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **397,037,349.58** | **448,791,647.20** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 110,004,949.58 | 226,714,447.20 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 110,004,949.58 | 226,714,447.20 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 287,032,400.00 | 222,077,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 287,032,400.00 | 222,077,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **435,178,828.12** | **589,639,835.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **435,178,828.12** | **589,639,835.86** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **415,928,094.34** | **521,220,138.89** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 81,818,866.76 | 138,815,728.20 |
| 210101 | Үндсэн цалин | 59,808,320.76 | 94,348,635.13 |
| 210102 | Нэмэгдэл | 15,257,473.00 | 38,919,493.51 |
| 210104 | Урамшуулал | 6,753,073.00 | 5,547,599.56 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 10,158,920.56 | 16,606,385.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,010,701.94 | 11,369,786.17 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 824,788.67 | 1,280,776.83 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 577,330.98 | 640,234.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 150,379.57 | 640,238.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,595,719.40 | 2,675,349.67 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 218,036,426.42 | 230,554,654.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,704,274.42 | 6,545,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 212,332,152.00 | 222,949,654.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 1,060,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,599,500.00 | 12,735,803.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 299,500.00 | 600,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500,000.00 | 1,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 1,500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 | 9,135,803.00 |
| 2105 | Нормативт зардал | - | 500,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 500,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,000,000.00 | 2,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 2,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 196,000.00 | 1,220,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 196,000.00 | 1,220,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,312,612.00 | 11,174,346.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,719,500.00 | 9,366,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 150,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 510,000.00 | 1,570,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 83,112.00 | 87,846.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 100,805,768.60 | 108,449,271.35 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 5,451,140.20 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 100,805,768.60 | 102,998,131.15 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19,250,733.78** | **68,419,696.97** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,843,870.00 | 2,338,500.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 752,200.00 | 1,558,500.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,375,670.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 716,000.00 | 780,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 66,081,196.97 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 66,081,196.97 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 12,406,863.78 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,406,863.78 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(8,322,178.54)** | **(120,333,348.62)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(8,322,178.54)** | **(120,333,348.62)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 173,579,922.10 | 619,436,473.05 | 3,045,953,165.71 | 3,838,969,560.86 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 173,579,922.10 | 619,436,473.05 | 3,045,953,165.71 | 3,838,969,560.86 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (8,322,178.54) | (8,322,178.54) |
| C08 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 173,579,922.10 | 619,436,473.05 | 3,037,630,987.17 | 3,830,647,382.32 |
| D01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 173,579,922.10 | 619,436,473.05 | 3,037,630,987.17 | 3,830,647,382.32 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 173,579,922.10 | 619,436,473.05 | 3,037,630,987.17 | 3,830,647,382.32 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (120,333,348.62) | (120,333,348.62) |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 173,579,922.10 | 619,436,473.05 | 2,917,297,638.55 | 3,710,314,033.70 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **399,321,149.58** | **459,031,647.20** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,283,800.00** | **10,240,000.00** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 2,283,800.00 | 10,240,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,283,800.00 | 10,240,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 913,800.00 | 10,240,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,370,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **397,037,349.58** | **448,791,647.20** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 10,004,949.58 | 226,714,447.20 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 110,004,949.58 | 226,714,447.20 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 287,032,400.00 | 222,077,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 287,032,400.00 | 222,077,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **396,332,969.32** | **475,490,356.97** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **396,332,969.32** | **475,490,356.97** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **377,082,235.54** | **407,070,660.00** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 81,818,866.76 | 138,815,728.20 |
| 210101 | Үндсэн цалин | 59,808,320.76 | 94,348,635.13 |
| 210102 | Нэмэгдэл | 15,257,473.00 | 38,919,493.51 |
| 210104 | Урамшуулал | 6,753,073.00 | 5,547,599.56 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 10,158,920.56 | 16,606,385.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,010,701.94 | 11,369,786.17 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 824,788.67 | 1,280,776.83 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 577,330.98 | 640,234.69 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 150,379.57 | 640,238.44 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,595,719.40 | 2,675,349.67 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 273,625,536.22 | 220,077,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,704,274.42 | 6,545,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 267,921,261.80 | 212,472,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 1,060,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,599,500.00 | 4,100,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 299,500.00 | 600,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500,000.00 | 1,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,000.00 | 1,500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 | 500,000.00 |
| 2105 | Нормативт зардал | - | 500,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 500,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,002,000.00 | 3,472,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,002,000.00 | 1,472,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 2,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 196,000.00 | 1,220,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 196,000.00 | 1,220,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,811,412.00 | 20,278,846.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,218,300.00 | 18,471,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 150,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 510,000.00 | 1,570,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 83,112.00 | 87,846.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,870,000.00 | 2,000,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,870,000.00 | 2,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **19,250,733.78** | **68,419,696.97** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,843,870.00 | 2,338,500.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 752,200.00 | 1,558,500.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 5,375,670.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 716,000.00 | 780,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 66,081,196.97 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 66,081,196.97 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 12,406,863.78 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,406,863.78 | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,988,180.26** | **(16,458,709.77)** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **8,680,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **8,680,000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 8,680,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 8,680,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(8,680,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | **2,988,180.26** | **(25,138,709.77)** |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 22,150,529.51 | 25,138,709.77 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 25,138,709.77 | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

/Төгрөгөөр/

| ЭЗА | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 25,138,709.77 | | |
| | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 236,554,500.00 | 196,011,960.00 | 40,542,540.00 | 82.9 |
| | УРСГАЛ ЗАРДАЛ | 236,554,500.00 | 196,011,960.00 | 40,542,540.00 | 82.9 |
| | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 234,216,000.00 | 193,673,460.00 | 40,542,540.00 | 82.7 |
| | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 173,007,100.00 | 138,815,728.20 | 34,191,371.80 | 80.2 |
| 210101 | Үндсэн цалин | 101,993,100.00 | 94,348,635.13 | 7,644,464.87 | 92.5 |
| 210102 | Нэмэгдэл | 56,446,800.00 | 38,919,493.51 | 17,527,306.49 | 68.9 |
| 210104 | Урамшуулал | 14,567,200.00 | 5,547,599.56 | 9,019,600.44 | 38.1 |
| | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 21,625,800.00 | 16,606,385.80 | 5,019,414.20 | 76.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,705,600.00 | 11,369,786.17 | 3,335,813.83 | 77.3 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,730,100.00 | 1,280,776.83 | 449,323.17 | 74.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 865,000.00 | 640,234.69 | 224,765.31 | 74.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 865,000.00 | 640,238.44 | 224,761.56 | 74.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,460,100.00 | 2,675,349.67 | 784,750.33 | 77.3 |
| | Хангамж, бараа материалын зардал | 5,100,000.00 | 5,100,000.00 | - | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 600,000.00 | 600,000.00 | - | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500,000.00 | 1,500,000.00 | - | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.00 | 500,000.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 | 500,000.00 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Нормативт зардал | 500,000.00 | 500,000.00 | - | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 500,000.00 | 500,000.00 | - | 100.0 |
| | Эд хогшил, урсгал засварын зардал | 9,156,100.00 | 9,152,500.00 | 3,600.00 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,156,100.00 | 9,152,500.00 | 3,600.00 | 100.0 |
| | Томилолт, зочны зардал | 1,300,000.00 | 1,220,000.00 | 80,000.00 | 93.8 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,300,000.00 | 1,220,000.00 | 80,000.00 | 93.8 |
| | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 21,527,000.00 | 20,278,846.00 | 1,248,154.00 | 94.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,957,000.00 | 18,471,000.00 | 486,000.00 | 97.4 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 150,000.00 | 150,000.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,320,000.00 | 1,570,000.00 | 750,000.00 | 67.7 |
| 210807 | Газрын төлбөр | 100,000.00 | 87,846.00 | 12,154.00 | 87.8 |
| | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.0 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,338,500.00 | 2,338,500.00 | - | 100.0 |
| | Бусад урсгал шилжүүлэг | 2,338,500.00 | 2,338,500.00 | - | 100.0 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,558,500.00 | 1,558,500.00 | - | 100.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 780,000.00 | 780,000.00 | - | 100.0 |
| | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 236,554,500.00 | 196,011,960.00 | 40,542,540.00 | 82.9 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 9,840,000.00 | 10,240,000.00 | (400,000.00) | 104.1 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 226,714,500.00 | 185771960 | 40,942,540.00 | 81.9 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 25,138,709.77 | (25,138,709.77) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - | - | - |

## Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Орон нутгийн төсөв/

/Төгрөгөөр/

| ЭЗА | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 222,077,200.00 | 222,077,200.00 | 0 | 100.0 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА | 222,077,200.00 | 222,077,200.00 | 0 | 100.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 222,077,200.00 | 222,077,200.00 | 0 | 100.0 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 222,077,200.00 | 222,077,200.00 | 0 | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 220,077,200.00 | 220,077,200.00 | 0 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,545,000.00 | 6,545,000.00 | 0 | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 212,472,200.00 | 212,472,200.00 | 0 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,060,000.00 | 1,060,000.00 | 0 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0 | 100.0 |
| | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 222,077,200.00 | 222,077,200.00 | 0 | 100.0 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 222,077,200.00 | 222,077,200.00 | 0 | 100.0 |
| | Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 0 | |

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 444.8 мянган төгрөгийн 4 зөрчил илрүүлж зөрчлийг арилгаж ажиллах хугацаатай 4 зөвлөмж хүргүүлсэн.

Аудитаар материаллаг алдаа, зөрчил илрээгүй тул өөрчлөлтгүй санал дүгнэлт хүргүүлэхээр шийдсэн болно.

### 5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Өр төлбөртэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* 2024 оны жилийн эцсийн байдлаар 10,477.5 мянган төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна. Мөн "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Төсвийг зохистой удирдаж өр, төлбөр үүсгэхгүй ажиллах.

**2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 59,913.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэнтэй нийцэхгүй байна.Мөн "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийн ашиглах хугацаа, үнэлгээг зохих журмын дагуу арга хэмжээг авч ажиллах

**3. Зардлын данстай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Дуу хөгжмийн багшаар 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр томилогдсон ажилтан 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс 24-ны өдөр хүртэл ажлын 15 хоногоор ээлжийн амралтаа бодуулан авч, Соёлын төвийн даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн ба тус ажилтны ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоог хийгээгүй байна. Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам" мөрдөж ажиллаагүй байна. Мөн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журмыг мөрдөн ажиллах.

**4. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Тайлант хугацаанд  нийт оруулбал зохих 171 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроосон, Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, холбогдох тушаал шийдвэрийг хавсралт файлаар оруулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэх

заалт, 6 дугаар зүйлийн 6.3.3.-т "төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар;"-г мөрдөж ажиллаагүй байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 20-ны fas.audit.mn сайтад байршуулан мэдээлж баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 2024 оны жилийн эцсийн байдлаар 10,477.5 мянган төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байна. | 1 | - | | - | | | 1 | - |
| Үлдэгдэл өртөггүй хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоогоогүй. | 1 | - | | | | - | 1 | - |
| Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн ажилласан хугацааны амралтын тооцоо хийгээгүй | 1 | 444.8 | | - | | - | 1 | 444.8 |
| **Дүн** | **3** | **444.8** | | **-** | | **-** | **3** | **444.8** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс |
|---|---|---|

| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансанд 5 мэдээлэл хугацаа хоцроосон, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар оруулж хэвшээгүй, холбогдох тушаал шийдвэрийг хавсралт файлаар оруулаагүй. | 1 | - | | | | - | 1 | - |
| **Дүн** | 1 | - | | | | - | 1 | - |